



## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2022/165/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954

Цахим хаяг: [huanganm@audit.gov.mn](mailto:huanganm@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930

Цахим хаяг: [jenisbekh@audit.gov.mn](mailto:jenisbekh@audit.gov.mn)

Аудитор: К.Риза

Утас: 94156768

Цахим хаяг: [Bayarmaar@audit.gov.mn](mailto:Bayarmaar@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Төлбөрийн акт.....	15
.....	
4.3 Албан шаардлага .....	15
4.4 Зөвлөмж .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgi@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ШҮҮХИЙН  
ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА  
ЦАГДААГИЙН ХОШУУЧ Д.СҮХБАТ ТАНАА

2022.02.09 № 27  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,584,732.24</u></b>	<b><u>3,745,161.05</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	0.00	0.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	0.00	160,228.81
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	160,228.81
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	3,584,732.24	3,584,932.24
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	168,260.00	168,260.00
35110	Тусгай зориулалттай материал	0.00	0.00
35130	Эм боох материал	168,260.00	168,260.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	3,416,472.24	3,416,672.24
35410	Бичиг хэргийн материал	530,000.00	530,000.00
35420	Аж ахуйн материал	2,542,524.99	2,542,724.99
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	0.00
35450	Барилгын засварын материал	51,500.00	51,500.00
35470	Бусад хангамжийн материал	292,447.25	292,447.25
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>142,004,146.89</u></b>	<b><u>137,576,313.89</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	142,004,146.89	137,576,313.89
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	115,559,146.89	111,131,313.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	69,233,440.00	69,233,440.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-3,220,159.92	-4,830,239.88
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,900,000.00	31,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-4,784,999.94	-6,379,999.92
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	57,642,348.60	58,342,348.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-38,120,667.15	-41,447,438.52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,441,960.29	6,152,460.29
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1,771,368.99	-2,077,850.68
39214	Бусад үндсэн хөрөнгө	238,594.00	238,594.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	26,445,000.00	26,445,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	26,445,000.00	26,445,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>145,588,879.13</u></b>	<b><u>141,321,474.94</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>0.00</u></b>	<b><u>0.00</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>145,588,879.13</u></b>	<b><u>141,321,474.94</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	145,588,879.13	141,321,474.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	27,540,818.00	27,540,818.00
51101	Өмч: - төрийн	27,540,818.00	27,540,818.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	117,809,467.13	113,542,062.94
51210	Өмнөх үеийн үр дүн	117,809,467.13	117,809,467.13
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-4,267,404.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	238,594.00	238,594.00

6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>145,588,879.13</u></b>	<b><u>141,321,474.94</u></b>
---	--	------------------------------	------------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>193,619,586.99</b>	<b>200,520,800.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>13,037,986.99</b>	<b>2,454,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	13,037,986.99	2,454,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	13,037,986.99	2,454,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,049,000.00	2,454,000.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	8,988,986.99	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>180,581,600.00</b>	<b>198,066,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	176,781,600.00	192,156,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	176,781,600.00	192,156,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,800,000.00	5,910,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,800,000.00	3,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,410,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>194,651,092.26</b>	<b>204,788,204.19</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>194,651,092.26</b>	<b>204,788,204.19</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	194,286,905.75	204,393,704.19
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	152,229,000.00	164,381,400.00
210101	Үндсэн цалин	83,566,000.00	87,345,522.00
210102	Нэмэгдэл	57,215,000.00	64,315,878.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,448,000.00	12,720,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	3,858,338.75	3,557,271.19
210201	Тэтгэврийн даатгал	1,258,338.75	-
210202	Тэтгэмжийн даатгал	-	159,771.19
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,600,000.00	3,397,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,552,242.00	9,632,400.00
210301	Гэрэл, цахилгаан	-	-
210302	Түлш, халаалт	4,252,242.00	5,212,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,300,000.00	920,000.00
210304	Байрны түрээс	-	3,500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,238,100.00	11,203,100.00
210401	Бичиг хэрэг	1,221,200.00	1,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,025,000.00	8,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	995,600.00	1,000,000.00
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	371,500.00	153,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	624,800.00	650,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3,593,200.00	3,600,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,593,200.00	3,600,000.00

<b>2106</b>	Эд хогшил, урсгал засварын зардал	373,000.00	1,721,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	373,000.00	1,721,700.00
<b>2107</b>	Томилолт, зочны зардал	3,413,300.00	2,000,000.00
210702	Дотоод албан томилолт	3,413,300.00	2,000,000.00
<b>2108</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	925,201.00	1,459,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	583,200.00	1,180,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,193.00	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	20,000.00
210807	Газрын төлбөр	43,308.00	100,000.00
<b>2109</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	13,104,524.00	6,838,333.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,800,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,304,524.00	6,838,333.00
<b>213</b>	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	364,186.51	394,500.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	364,186.51	394,500.00
<b>3</b>	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<b>(1,031,505.27)</b>	<b>(4,267,404.19)</b>
<b>5</b>	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<b>(1,031,505.27)</b>	<b>(4,267,404.19)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	27,540,818.00	238,594.00	117,809,467.13	145,588,879.13
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	27,540,818.00	238,594.00	117,809,467.13	145,588,879.13
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	27,540,818.00	238,594.00	117,809,467.13	145,588,879.13
D08	Тайлант үеийн үр дүн			-4,267,404.19	-4,267,404.19
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	27,540,818.00	238,594.00	113,542,062.94	141,321,474.94

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>184,630,600.00</b>	<b>200,520,800.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,049,000.00</b>	<b>2,454,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,049,000.00	2,454,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	4,049,000.00	2,454,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,049,000.00	2,454,000.00

<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>180,581,600.00</b>	<b>198,066,800.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,800,000.00	5,910,500.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,800,000.00	3,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,410,500.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	176,781,600.00	192,156,300.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	176,781,600.00	192,156,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>184,630,600.00</b>	<b>198,110,300.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>184,630,600.00</b>	<b>198,110,300.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>184,266,413.49</b>	<b>197,715,800.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	152,229,000.00	164,381,400.00
210101	Үндсэн цалин	83,566,000.00	87,345,522.00
210102	Нэмэгдэл	57,215,000.00	64,315,878.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,448,000.00	12,720,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	3,122,370.49	3,717,500.00
210201	Тэтгэврийн даатгал	522,370.49	
210202	Тэтгэмжийн даатгал		320,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,600,000.00	3,397,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,552,242.00	9,632,400.00
210301	Гэрэл, цахилгаан		
210302	Түлш, халаалт	4,252,242.00	5,212,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,300,000.00	920,000.00
210304	Байрны түрээс		3,500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,258,100.00	11,203,100.00
210401	Бичиг хэрэг	1,221,200.00	1,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,025,000.00	8,400,000.00
210403	Шүүдан, холбоо, интернэтийн төлбөр	995,600.00	1,000,000.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	371,500.00	153,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	644,800.00	650,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3,593,200.00	3,600,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,593,200.00	3,600,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	373,000.00	1,721,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	373,000.00	1,721,900.00
210604	Урсгал засвар		
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,413,300.00	2,000,000.00
210702	Дотоод албан томилолт	3,413,300.00	2,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	925,201.00	1,459,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	583,200.00	1,180,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,193.00	80,000.00

Аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	20,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		
210807	Газрын төлбөр	43,308.00	100,000.00
<b>2109</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	3,800,000.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,800,000.00	
<b>213</b>	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	364,186.51	394,500.00
<b>2133</b>	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	364,186.51	394,500.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	364,186.51	394,500.00
<b>3</b>	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (3)=(1)-(2)	<u>0.00</u>	<u>2,410,500.00</u>
<b>5</b>	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дун (5)	0.00	2,410,500.00
<b>22</b>	хөрөнгийн зардал	0.00	2,410,500.00
<b>2200</b>	дотоод эх үүсвэрээр	0.00	2,410,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		2,410,500.00
<b>6</b>	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>0.00</u>	<u>-2,410,500.00</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	180,650,600.00	180,466,443.00	194,256,300.00	194,215,800.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	180,650,600.00	180,466,443.00	194,256,300.00	194,215,800.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	180,650,600.00	180,466,443.00	194,256,300.00	194,215,800.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	152,229,000.00	152,229,000.00	164,381,400.00	164,381,400.00
210101	Үндсэн цалин	83,566,000.00	83,566,000.00	87,812,400.00	87,345,522.00
210102	Нэмэгдэл	57,215,000.00	57,215,000.00	63,849,000.00	64,315,878.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,448,000.00	11,448,000.00	12,720,000.00	12,720,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх үлдэгдэл</b>	3,122,400.00	3,122,400.00	3,717,500.00	3,717,500.00
210201	Тэтгэврийн даатгал	522,400.00	522,400.00		
210202	Тэтгэмжийн даатгал			320,000.00	320,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,600,000.00	2,600,000.00	3,397,500.00	3,397,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,552,300.00	5,552,242.00	6,132,400.00	6,132,400.00
210301	Гэрэл, цахилгаан				
210302	Түлш, халаалт	4,252,300.00	4,252,242.00	5,212,400.00	5,212,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,300,000.00	1,300,000.00	920,000.00	920,000.00
210304	Байрны түрээс				
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,313,000.00	11,258,100.00	11,203,100.00	11,203,100.00
210401	Бичиг хэрэг	1,221,200.00	1,221,200.00	1,000,000.00	1,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,025,000.00	8,025,000.00	8,400,000.00	8,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	995,600.00	995,600.00	1,000,000.00	1,000,000.00
210404	Ном, хэвлэл				
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	426,400.00	371,500.00	153,100.00	153,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	644,800.00	644,800.00	650,000.00	650,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал				
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3,593,200.00	3,593,200.00	3,600,000.00	3,600,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,593,200.00	3,593,200.00	3,600,000.00	3,600,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	444,700.00	373,000.00	1,721,900.00	1,721,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл				
210602	Тавилга				
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	444,700.00	373,000.00	1,721,900.00	1,721,900.00
210604	Урсгал засвар				
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	3,413,300.00	3,413,300.00	2,000,000.00	2,000,000.00
210701	Гадаад албан томилолт				
210702	Дотоод албан томилолт	3,413,300.00	3,413,300.00	2,000,000.00	2,000,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах				
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал</b>	982,700.00	925,201.00	1,500,000.00	1,459,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	583,200.00	583,200.00	1,180,000.00	1,180,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	120,000.00		
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	79,500.00	120,000.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	79,193.00	80,000.00	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	20,000.00	20,000.00	20,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ				
210807	Газрын төлбөр	100,000.00	43,308.00	100,000.00	100,000.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	180,650,600.00	180,466,413.49	194,256,300.00	194,569,800.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	176,781,600.00	176,597,413.49	192,156,300.00	192,115,800.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	176,781,600.00	176,597,413.49	192,156,300.00	192,115,800.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГ</b>	3,869,000.00	3,869,000.00	2,100,000.00	2,454,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэх	3,869,000.00	3,869,000.00	2,100,000.00	2,454,000.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	9.00	9.00	10.00	10.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00	9.00	9.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,800,000.00</b>	<b>5,910,500.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,800,000.00</b>	<b>5,910,500.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,800,000.00	5,910,500.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	3,800,000.00	3,500,000.00
210304	Байрны түрээс	3,800,000.00	3,500,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	0.00	2,410,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		700,000.00
210602	Тавилга		1,710,500.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	3,800,000.00	5,910,500.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,800,000.00	5,910,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,800,000.00	3,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,410,500.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд Аймгийн Шүүхийн шинжилгээний албатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл, гэрээт аудитор К.Риза нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн №13 б/11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шүүхийн шинжилгээний байгууллагын эрхэм зорилго нь Монгол Улсын хэмжээнд шүүхийн шинжилгээний үйл ажиллагааг цогц хэлбэрээр нь хөгжүүлж, дэвшилтэт техник, технологи бүхий шинжилгээний лабораториудыг ашиглан тусгай мэдлэг, мэргэжлийн хүрээнд аливаа шинжилгээг хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах, мэргэшсэн албан хаагчдын хүний нөөц бүрдүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хуул зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/216 тоот тушаалаар Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, Дотоод хяналт, алба хаагчдын сахилга, ёс зүй хариуцсан чиглэлийн ахлах мэргэжилтэн, Хяналт шалгалт, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн, Өргөдөл гомдлын шийдвэрлэлт хариуцсан мэргэжилтэн, Санхүүгийн аудит хариуцсан мэргэжилтэн нийт 5 орон тоотой ажиллаж байна.

Тус албаны үйл ажиллагаанд 2021 оны 09 дүгээр сард дотоод аудитын албанаас 2 хүний бүрэлдэхүүнтэй шалгалтын баг ирж шалгалт хийгдсэн ба шалгалтаар зөрчил илрээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өлгий аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 194,6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 3,9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3,0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4.3 сая төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.00	160.2	160.2
Бараа материал	3,584.7	3,584.9	0.2
Үндсэн хөрөнгө	142,004.1	137,576.3	-4427.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>145,588.9</b>	<b>141,321.5</b>	<b>-4267.4</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	145,588.9	141,321.5	-4267.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>145,588.9</b>	<b>141,321.5</b>	<b>-4267.4</b>

Мөнгөн хөрөнгө данс үлдэгдэлгүй байна. Авлага дансны үлдэгдэл нь нэг ажилтанд илүү тооцогдсон цалинг суутгаагүйтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл оны эхэн болон эцэст 3.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн хөрөнгөөр 1.0 сая төгрөгийн бичиг хэрэг, 2.8 сая төгрөгийн аж ахуйн материал, 8.4 сая төгрөгийн түлш шатах тослох материал, 0.3 сая төгрөгийн бусад хангамжийн материал нийтдээ 16.1 сая төгрөгийн бараа материалыг орлого авч, 16.1 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эцэст 141.3 сая төгрөг болж 4.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд худалдаж авсан үндсэн хөрөнгийн дүн, элэгдлийн зардлын дүнгийн зөрүүгээр буурсан байна.

Сангийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217 тоот тушаалаар Шүүхийн шинжилгээний системийн байгууллагуудын тайлант хугацаанд төсөвт төвлөрүүлсэн өөрийн орлогын давсан хэсгийг нэмэлт дансанд шилжүүлэн зарцуулах эрх олгосны дагуу 2.4 сая төгрөгийг нэмэлт дэнсаар дамжуулан тавилга, тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Оны эхэн болон эцэст өр төлбөр гараагүй байна. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 6.9 сая төгрөгөөр буюу 3.6 хувиар өссөн нь өөрийн орлогын давсан хэсэг болон аймгийн Орон нутгийн орлогын давсан хэсгээс олгосон 3.5 сая төгрөгийн байрны түрээсийн зардалтай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 10.1 сая төгрөгөөр буюу 5.2 хувиар өссөн нь Орон нутгийн орлогын давсан хэсгээс олгосон 3.5 сая төгрөгийг байгууллагын даргын байрны түрээсийн

төлбөрт төлсөн, төсвөөс буцааж олгосон өөрийн орлогын давсан хэсгийн 2.4 сая төгрөгийг байгууллагад тавилга, тоног төхөөрөмж худалдан авахад зориулж зарцуулсан зэрэг нь нөлөөлжээ.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд санхүүжилтийн орлогыг 295.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 295.1 сая төгрөгөөр тооцон төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг хянаж, нийт дүнгээр 95.5 сая төгрөгөөр бууруулан 2021 оны төсвийг 199.6 сая төгрөгөөр батлан төсвийн хуваарь ирүүлжээ.

Төсвийн жилийн дундуур тайлант оны төсөвт өөрчлөлт оруулан анхны төсвийн хэмжээг 2.8 хувиар буюу 5.4 сая төгрөгөөр бууруулан тодотгож, тайлант оны төсвийг 194.2 сая төгрөгөөр батлан ирүүлжээ. Нийт зарлагын 192.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 2.1 сая төгрөгийг өөрийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Анхны болон тодотгосон төсөвт орон тоог 10 хүнээр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 192.1 сая төгрөгийн, өөрийн орлогоос 2.4 сая төгрөгийн нийтдээ 194.5 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр үйл ажиллагаа явуулахаас үйл ажиллагаандаа 194.2 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 40.5 мянган төгрөгөөр хэмнэж, өөрийн орлогын төлөвлөгөөнөөс илүү оруулсан 354.0 мянган төгрөг нийтдээ 394.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант онд төлөвлөгөөгөөр өөрийн орлогоос 2.1 сая төгрөг оруулахаас гүйцэтгэлээр 4.8 сая төгрөгийг шинжилгээний хөлс болон үйлчилгээний хөлс хураамжаас оруулан, 2.1 сая төгрөгийг үйл ажиллагааны төсөвт зарцуулж, 354,0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэн, орлогын давсан хэсгийн 2.4 сая төгрөгийг Сангийн сайдын шийдвэрээр нэмэлт санхүүжилтээр зарцуулж байгууллагын хэрэгцээнд тавилга, тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 194.2 сая төгрөг буюу 99.8 хувьтай байна.

Нийт төсвийн 84.7 хувийг цалин, НДШ-ийн зардал, 3.1 хувийг тогтмол зардал, 5.8 хувийг хангамж бараа материалын зардал, 1.8 хувийг норматив зардал, 4.6 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаа явуулсан ба тус албаны оны эхний батлагдсан төсвийг 2.8 хувиар хасаж тодотгосоноор Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн хэмжээнд Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлсэн гэж үзэх үндэслэлтэй байна.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансанд Орон нутгийн орлогын давсан хэсгээс зохих шийдвэрийн дагуу байр ашиглалттай холбоотой зардалд зориулан 3.5 мянган төгрөгийн, өөрийн орлогын давсан хэсгээс 2.4 сая төгрөгийн нийтдээ 5.9 сая төгрөгийн хөрөнгө хуваарилагдсаныг зориулалтын дагуу зарцуулжээ.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Шүүхийн шинжилгээний албанаас бэлтгэж ирүүлсэн 2021 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал ороогүй байна.

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулсан ба байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдол гараагүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүссэн тухай, санхүүгийн тайлангийн аудит, аудитын тайлантай холбоотой аудиторын хүлээх үүрэг хариуцлагын тухай дэлгэрэнгүй тайлбар өгөхөөр асуудал үүсээгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 119 мэдээллээс 118 мэдээллийг хугацаандаа байршуулж, 1 мэдээллийг хугацаа хожимдуулсан ба хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээ гараагүй байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн Шилэн дансны тухай хууль болон Засгийн

газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 118 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулан мэдээлэл оруулсан байдлын хэрэгжилтийн хувь 99.3 хувьтай, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасан байдаг.

Тайлант оны орлого, зарлагын гүйлгээ хууль журмын дагуу хийгдсэн эсэхийг шалгаж үзэхэд баримтын бүрдэлтийг хуулинд заасны дагуу бүрдүүлсэний дагуу орлого, зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх онд зөвлөмж өгөгдөөгүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй

#### **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар шилэн дансанд 1 мэдээллийг хугацаа хожимдуулан байршуулсанаас бусад алдаа зөрчил илрээгүй болно.

##### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа гараагүй болно.

##### **4.2 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогдоогүй

##### **4.3 Албан шаардлага**

Албан шаардлага өгөгдөөгүй

##### **4.4 Зөвлөмж**

Зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

